



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 11 сарын 09 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

「Хувьцаа эзэмшигчийг төлөөлөн оролцох
төлөөлөгчийг томилж, удирдамж батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд хувьцаа эзэмшигчийг төлөөлөн оролцох төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга Цэрэннадмидын Шинэхүүг томилсугай.

2. “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг хувьцаа эзэмшигчийг төлөөлөн оролцох төлөөлөгч Цэрэннадмидын Шинэхүүд даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013726

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2023 оны 11 сарын 09-ны
өдрийн 4/94 дугаартай тушаалын хавсралт

**“ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ
ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Хувьцаа эзэмшигчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалд шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон энэхүү удирдамжийг баримтална:

1. Нүүрс баяжуулах болон Хагас коксын үйлдвэрийн төслийн талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай асуудлыг судлан, төслийн хэрэгжилттэй танилцаж, төслийг цаашид амжилттай хэрэгжүүлэх талаар Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад үүрэг, чиглэл өгөх;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу дуусгавар болгож, сонгох.

-----oOo-----